



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 76


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Г.ЗАНДАНШАТАР

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Засгийн газрын 2026 оны 03 дугаар
сарын 11-ний өдрийн 76 дугаар
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.“Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-аар Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц (цаашид “Конвенц” гэх)-ын Хавсралт 19 “Аюулгүй байдлын удирдлага” (цаашид “Хавсралт 19” гэх)-д заасны дагуу иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт, эрсдэлийн удирдлага, аюулгүй байдлын баталгаажуулалт, сургалт, сурталчилгааны шаардлагад нийцсэн иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтыг бий болгоно.

1.2.Энэ журмыг нисэхийн үйл ажиллагаанд оролцогч дараах талууд хэрэгжүүлж ажиллана:

1.2.1.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

1.2.2.Иргэний нисэхийн ерөнхий газар;

1.2.3.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба;

1.2.4.иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага;

1.2.5.нисэхийн аюулгүй байдлын чиглэлээр үүрэг, хариуцлага хүлээсэн холбогдох бусад төрийн байгууллага.

1.3.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“алдаа” гэж журмын 1.2-т заасан байгууллага, эсхүл үйл ажиллагаа хариуцсан ажилтны хүсэл зорилго, итгэл үнэмшлээс гажихад хүргэдэг, тухайн ажилтны үйлдэл, эс үйлдлийг;

1.3.2.“аюул” гэж агаарын хөлгийн осол, эсхүл зөрчилд хүргэх бодит шалтгаан, нөлөөлөх нөхцөл, эсхүл биет зүйлийг;

1.3.3.“аюулгүй байдал” гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, эсхүл түүнд шууд дэмжлэг үзүүлэх нисэхийн үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд бууруулах болон уг үйл ажиллагааг хянах төлөв байдлыг;

1.3.4.“аюулгүй байдлын гүйцэтгэл” гэж улс, эсхүл үйлчилгээ эрхлэгч байгууллагын аюулгүй байдлын зорилгод хүрэхэд үзүүлж байгаа хэмжиж болох үр нөлөөг;

1.3.5.“аюулгүй байдлын гүйцэтгэлийн зорилт” гэж улс, эсхүл үйлчилгээ эрхлэгч байгууллагын тодорхой хугацаанд хүрэхээр төлөвлөсөн, урьдчилан тодорхойлсон аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийн зорилтот түвшинг;

1.3.6.“аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт” гэж улс, эсхүл үйлчилгээ эрхлэгч байгууллагын тогтоосон аюулгүй байдлын зорилгод хүрэхийн тулд аюулгүй байдлын гүйцэтгэлийг хэмжих, хянахад ашиглагддаг хэмжүүрийг;

1.3.7.“аюулгүй байдлын зорилго” гэж хүсэж буй аюулгүй байдлын үр дүнг илэрхийлсэн мэдэгдлийг;

1.3.8.“аюулгүй байдлын зорилтот түвшин” гэж тодорхой нөхцөл байдалд хүлээн зөвшөөрөгдөхүйц гэж үзсэн, эрсдэлийн түвшнийг илэрхийлдэг ерөнхий нэр томъёог;

1.3.9.“аюулгүй байдлын зөвлөмж” гэж Иргэний нисэхийн тухай хуулийн 5.1.5-д заасныг;

1.3.10.“аюулгүй байдлын мэдээлэл” гэж аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэх болон аюулгүй байдлын оновчтой шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой нөхцөл, хүрээнд боловсруулагдсан, ангилсан, эсхүл шинжилсэн аюулгүй байдлын өгөгдлийг;

1.3.11.“аюулгүй байдлын өгөгдөл” гэж аюулгүй байдлыг хадгалах, сайжруулах зорилгоор ашиглаж болох, иш татах, боловсруулах, эсхүл шинжлэх зорилгоор цуглуулсан тодорхой баримт, утгуудын багцыг;

1.3.12.“аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо” гэж аюулгүй байдлыг удирдахад шаардлагатай байгууллагын бүтэц, зохион байгуулалт үүрэг, хариуцлага, бодлого болон журмыг багтаасан системчилсэн хандлагыг;

1.3.13.“аюулгүй байдлын хяналт зохицуулалт” гэж нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, хуулийн этгээд нь аюулгүй байдалтай холбоотой үндэсний хууль, дүрмийг дагаж мөрдөж байгааг бататгах зорилгоор төрөөс хэрэгжүүлдэг хяналт зохицуулалтын ажиллагааг;

1.3.14.“аюулгүй байдлын эрсдэл” гэж аюулын үр дагавар, нөлөөлөл, илрэх магадлал болон түүний хүндрэлийг урьдчилан таамагласан үнэлгээг;

1.3.15.“зөрчил” гэж Иргэний нисэхийн тухай хуулийн 5.1.8-д заасныг;

1.3.16.“Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө” гэж нисэхийн аюулгүй байдлын гол эрсдэл, сорилтыг шийдвэрлэхэд чиглэсэн, олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн боловсруулсан төлөвлөгөөг;

1.3.17.“иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн байгууллага” гэж Конвенцын Хавсралт 19-ийн дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээ эзэмшигч дараах байгууллагыг хэлнэ:

1.3.17.1.үйлчилгээ үзүүлэх явцад агаарын хөлгийн ашиглалттай холбоотой аюулгүй байдлын эрсдэлд өртдөг, Конвенцын Хавсралт 1 “Хувь хүний үнэмлэхжүүлэлт”-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллага;

1.3.17.2.Конвенцын Хавсралт 6 “Агаарын хөлгийн үйл ажиллагаа” (цаашид “Хавсралт 6” гэх), Боть I, эсхүл III-ийн дагуу арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний үйл ажиллагаа эрхлэгч;

1.3.17.3.Конвенцын Хавсралт 6, Боть IV-ийн дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй Зайнаас удирддаг агаарын хөлгийн систем (RPAS)-ийн үйл ажиллагаа эрхлэгч;

1.3.17.4.Конвенцын Хавсралт 6, Боть I, Боть III-ийн дагуу арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний үйл ажиллагаа эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлдэг гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллага;

1.3.17.5.Конвенцын Хавсралт 6, Боть IV-ийн дагуу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй Зайнаас удирддаг агаарын хөлгийн систем (RPAS)-ийн үйл ажиллагаа эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлдэг гэрчилгээжсэн агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага;

1.3.17.6.Конвенцын Хавсралт 8 “Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар”-ын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлөг, хөдөлгүүр, эсхүл сэнсний зохион бүтээгч, үйлдвэрлэгч байгууллага;

1.3.17.7.Конвенцын Хавсралт 11 “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ”-ний дагуу нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэгч байгууллага;

1.3.17.8.Конвенцын Хавсралт 14 “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт”, Боть I, Боть II-ийн тус бүрийн дагуу гэрчилгээжсэн аэродром.

1.3.18.“ноцтой зөрчил” гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох ослоос бусад эрсдэл бүхий дараах тохиолдлыг хэлнэ:

1.3.18.1.хүнтэй агаарын хөлгийн хувьд: нислэгийн зорилгоор аливаа этгээд агаарын хөлөгт орсон цагаас эхлээд тухайн этгээд буух цаг хугацааны хооронд болсон, осол болох өндөр магадлалтай нөхцөлд гарсан зөрчлийг;

1.3.18.2.хүнгүй агаарын хөлгийн хувьд: тухайн нислэгийн зорилгоор агаарын хөлөг хөдлөхөд бэлэн болсон цагаас эхлээд нислэгийн төгсгөлд зогсож, үндсэн хөдөлгүүрээ унтраах хүртэлх хугацааны хооронд болсон, осол болох өндөр магадлалтай нөхцөлд гарсан зөрчлийг.

1.3.19.“осол” гэж Иргэний нисэхийн тухай хуулийн 1.5.19-д заасныг.

Хоёр.Иргэний нисэхийн аюулгүй
байдлын бодлого, зорилт

2.1.Үндэсний хууль тогтоомж болон Конвенц, түүний Хавсралтад нийцүүлэн иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах талаар дараах бодлогыг хэрэгжүүлнэ:

2.1.1.бодлого, шийдвэр гаргахдаа нисэхийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангуулах;

2.1.2.иргэний нисэхийн салбарыг системтэй, тогтвортой хөгжүүлэх зорилгоор Конвенц, түүний Хавсралтад нийцүүлэн иргэний нисэхийн хууль тогтоомж, эрх зүйн орчинд тогтмол дүн шинжилгээ хийх, шинэчлэх, сайжруулах;

2.1.3.аюулгүй байдлын мэдээллийн дүн шинжилгээ, эрсдэлийн удирдлагад суурилсан иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын тогтолцоог бий болгох, бэхжүүлэх;

2.1.4.улсын хэмжээнд хянах иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшнийг тогтоож, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хянах, тасралтгүй сайжруулах;

2.1.5.салбарын хэмжээнд иргэний нисэхийн аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлж, сайжруулах;

2.1.6.салбарын хэмжээнд агаарын хөлгийн осол, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, гарсан тохиолдол бүрд дүн шинжилгээ хийх, аюулгүй байдлын эерэг, шударга соёлыг нэвтрүүлэх;

2.1.7.хууль тогтоомжид өөрөөр зааснаас бусад тохиолдолд аюулгүй байдлын мэдээллийн эх сурвалжийг хамгаалж, мэдээллийг зөвхөн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор ашиглах;

2.1.8.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа болон иргэний нисэхийн хяналт зохицуулалтыг Конвенц, түүний Хавсралтад нийцүүлэн тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор зохистой тооны мэргэшсэн хүний нөөц, хяналт шалгалт болон шинжлэн шалгах ажиллагаа хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, тээврийн хэрэгсэл, ажлын байраар хангах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх;

2.1.9.иргэний нисэхийн салбарт мэргэшсэн хүний нөөцийн дутагдал үүсэхээс сэргийлж хүний нөөцийг тасралтгүй бэлтгэх, мэргэшүүлэх, чадамжийг дээшлүүлэх;

2.1.10.энэ журмын хэрэгжилтийг хангуулах хүрээнд холбогдох бүх төрийн байгууллага, агаарын тээврийн оролцогч талуудын хооронд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох;

2.1.11.иргэний нисэхийн чиглэлээр олон улсын байгууллага, улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, үндэсний ашиг сонирхлыг олон улсын тавцанд илэрхийлэх, хамгаалах зорилгоор хамтын шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох;

2.1.12.салбарыг шинэ техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий салбар болгон бэхжүүлэх;

2.1.13.зах зээлийн шударга өрсөлдөөнийг дэмжиж, оролцогч талуудын тэгш эрх, боломжийг хангах;

2.1.14.зорчигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг, хамгаалах.

2.2.Иргэний нисэхийн аюулгүй байдлын дараах 6 зорилтыг нэн тэргүүнд хэрэгжүүлнэ:

2.2.1.улсын хэмжээнд нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийг тогтвортой бууруулах;

2.2.2.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын болон агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны чадамжийг бэхжүүлэх;

2.2.3.аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавих;

2.2.4.нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэх чиглэлээр дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагааг өргөжүүлж, бэхжүүлэх;

2.2.5.нисэхийн оролцогч талуудыг нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд татан оролцуулж, хамтын ажиллагааг дэмжих, аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоог бий болгох;

2.2.6.нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай зохих дэд бүтэц бий болсон эсэхийг бататгаж, салбарын хэмжээнд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах.

2.3.Улсын хэмжээнд хянах иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид "ОУИНБ" гэх)-аас гаргасан нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдлын өндөр эрсдэлийн дараах ангиллаар тогтооно:

2.3.1.хяналттай нислэг газрын гадаргууг мөргөх (Controlled Flight into Terrain-CFIT);

2.3.2.нислэгийн үеэр удирдлагын жолоо алдагдах (Loss of Control-In Flight-LOC-I);

2.3.3.агаарын хөлгүүд агаарт мөргөлдөх (Mid-Air Collision-MAC);

2.3.4.хөөрч, буух зурвасаас гарах (Runway Excursion-RE);

2.3.5.хөөрч, буух зурвас руу зөвшөөрөлгүй нэвтрэх (Runway Incursion-RI);

2.3.6.аэродром дээр болон аэродромын орчинд зэрлэг амьтан, шувуутай мөргөлдөх (Wildlife Strike-WS);

2.3.7. агаарын хөлгийн хөөрч, буух зурвас дахь хэвийн бус буулт-Агаарын хөлөг хатуу буух, агаарын хөлөг сүүл хэсгээрээ газарт хүрэх (Abnormal Runway Contact-ARC, including Hard Landing and Tail Strike Landing);

2.3.8. нислэгийн үед агаарын хөлөг сэгсрэлтэнд орох (Turbulence encounter-TURB);

2.3.9. хүчний төхөөрөмжөөс бусад систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction (non-powerplant-SCF-NP);

2.3.10. хүчний төхөөрөмжийн систем, эд ангийн дутагдал, эсхүл эвдрэл (System/component failure or malfunction (powerplant-SCF-PP).

2.4. Энэ журмын 2.2-т заасан аюулгүй байдлын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

2.5. Нисэхийн салбарын оролцогч талууд энэ журмын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах эрх зүйн баримт бичгийг мөрдөнө:

2.5.1. Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж;

2.5.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө;

2.5.3. ИНД-100 Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;

2.5.4. иргэний нисэхийн дүрэм, журам, баримт бичиг;

2.5.5. Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргасан аюулгүй байдлын мэдэгдэл, журам, заавар, зөвлөмжийн цуврал болон албан шаардлага.

2.6. Иргэний нисэхийн ерөнхий газар нь агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил, эсхүл онцгой байдал, хямралын нөхцөл үүссэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөлт (Emergency Response Planning) болон хямралын удирдлага (Crisis Management)-ыг хэрэгжүүлж, салбарын оролцогч талуудын үйл ажиллагааны уялдааг хангана.

2.7. Иргэний нисэхийн ерөнхий газар нь батлагдсан аюулгүй байдлын бодлого, зорилтыг холбогдох төрийн байгууллага болон салбарын оролцогч талуудад нээлттэй танилцуулж, мэдээлнэ.

2.8. Энэ журмын 2.1 болон 2.2-т заасан иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилтод салбарын оролцогч талуудын хүсэлтийн дагуу аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Гурав.Нисэхийн салбарын оролцогч
талуудын үүрэг

3.1.Иргэний нисэхийн ерөнхий газрын үүрэг:

3.1.1.Конвенцын Хавсралт 19-д заасны дагуу иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага, аюулгүй байдлын баталгаажуулалт, сургалт, сурталчилгааны шаардлагад нийцсэн иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлд суурилсан хяналт зохицуулалтыг бий болгох;

3.1.2.иргэний нисэхийн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг гүйцэтгэх;

3.1.3.иргэний нисэхийн хяналт, шалгалттай холбогдуулан Конвенцын Хавсралт 19-ийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;

3.1.4.Конвенц, түүний Хавсралтад нийцүүлэн иргэний нисэхийн дүрэм, зөвлөмжийн цуврал, маягт, журам, заавар, гарын авлага, зааварчилгаа, албан даалгавар болон бусад баримт бичгийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.5.иргэний нисэхийн дүрэм болон Конвенц, түүний Хавсралтад заасан стандартын зөрүүтэй байдлыг ОУИНБ-д мэдээлэх;

3.1.6.хууль, дүрэм, журам, зааврыг дагаж мөрдүүлэх зорилгоор албадлагын арга хэмжээг хүн, хуулийн этгээдэд хэрэгжүүлэх;

3.1.7.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн гэрчилгээжсэн ажилтны үнэмлэх, зэрэглэл олгох;

3.1.8.Конвенцын Хавсралт 19-ийн дагуу төрийн байгууллага болон иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд хоорондын аюулгүй байдлын үүрэг, хариуцлагыг тэнцвэржүүлж, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.9.салбарын хэмжээнд аюулгүй байдлын өгөгдөл, мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлэх;

3.1.10.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн санг хөтлөх, хамгаалах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн санд тулгуурласан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;

3.1.11.улсын хэмжээнд хянах иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, анхааруулах түвшин, зорилтот түвшнийг тогтоож, гүйцэтгэлийг тогтмол хянах;

3.1.12.тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, онцлогт нийцүүлэн тогтоосон иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагын аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, анхааруулах түвшин, зорилтот түвшнийг хүлээн зөвшөөрч, хяналт шалгалтын үйл ажиллагааны хүрээнд тогтмол хяналт тавих;

3.1.13.хяналт шалгалтаар илэрсэн үл нийцэл, шаардлага болон аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөг Конвенцын Хавсралт 19-д заасан стандарт, зөвлөмжийн дагуу тогтмол хянах, үнэлэх;

3.1.14.иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн хүний нөөц, санхүүгийн чадамж, баримт бичиг, тоног төхөөрөмж, багаж, тээврийн хэрэгсэл, ажлын байрыг бүрдүүлэх;

3.1.15.иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх урт хугацааны хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулж, хүний нөөцийг тасралтгүй мэргэшүүлэх;

3.1.16.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба болон энэ журмыг хэрэгжүүлэх аюулгүй байдлын техникийн багийг байгуулах;

3.1.17.аюулгүй байдлын техникийн багаас гүйцэтгэсэн салбарын хэмжээний аюулгүй байдлын өгөгдөл, эрсдэлийн дүн шинжилгээнд үндэслэн аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ авах;

3.1.18.иргэний нисэхийн аюулгүй байдлын гүйцэтгэлийг баталгаажуулж, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэх;

3.1.19.иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд болон нисэхийн салбарын бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг дэмжих;

3.1.20.иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулахад шаардлагатай сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, салбарын хэмжээнд аюулгүй байдлын эерэг, шударга соёлыг бүрдүүлэх;

3.1.21.агаарын тээврийн салбарын хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар ОУИНБ-аас баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах;

3.1.22.Конвенцын Хавсралт 19-ийн хүрээнд иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх;

3.1.23.Конвенцын Хавсралт 19-ийн дагуу баримт бичгийн бүртгэл, хяналтын сан, салбарын аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын мэдээллийн сан, салбарын аюулгүй байдлын гүйцэтгэлд баталгаажуулалт хийсэн бүртгэл, иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны мэдээллийн сан, салбарын аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцооны өгөгдлийн сан, аюулгүй байдлын сургалт, сурталчилгааны баримт, материалын санг үүсгэж, хадгалж, хамгаалах;

3.1.24.Монгол Улсыг ОУИНБ-д төлөөлж, тус байгууллагаас баримталж байгаа бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх;

3.1.25.Конвенцын хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, нисэхийн аюулгүй байдлын уулзалт, зөвлөгөөнд оролцох, харилцан мэдээлэл солилцох;

3.1.26.энэ журмыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг жил бүр боловсруулж, батлах, хэрэгжилтэд хяналт тавих.

3.2.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны үүрэг:

3.2.1.Конвенцын Хавсралт 13 стандартын хүрээнд агаарын хөлгийн осол, зөрчилд бие даасан шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;

3.2.2.аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хуваалцах, солилцох үйл ажиллагааг дэмжих;

3.2.3.иргэний нисэхийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй аюулгүй байдлын асуудлаар салбарын оролцогч талуудтай хамтран ажиллах;

3.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдлыг сурталчлах сургалт, сурталчилгааны ажлыг дэмжих, идэвхтэй оролцох.

3.3.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн гишүүн, нисэхийн салбарын оролцогч бусад төрийн байгууллагын үүрэг:

3.3.1.салбарын хэмжээнд аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл ажиллагаанд оролцох;

3.3.2.аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хуваалцах, солилцох үйл ажиллагааг дэмжих;

3.3.3.иргэний нисэхийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй аюулгүй байдлын асуудлаар салбарын оролцогч талуудтай хамтран ажиллах;

3.3.4.иргэний нисэхийн аюулгүй байдлыг сурталчлах сургалт, сурталчилгааны ажлыг дэмжих, идэвхтэй оролцох.

3.4.Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын үүрэг:

3.4.1.иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагаас салбарын хэмжээнд заавал дагаж мөрдөхөөр гаргасан захиргааны хэм хэмжээний акт болон захиргааны актыг мөрдөж, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах;

3.4.2.иргэний нисэхийн дүрмийн дагуу үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанар, онцлогт нийцсэн үр нөлөөтэй аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах;

3.4.3.иргэний нисэхийн дүрмийн дагуу заавал мэдээлэх агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил, зөрчлийн мэдээлэл болон сайн дурын аюул, эрсдэлийн талаарх мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдээлэх;

3.4.4.иргэний нисэхийн дүрмийн дагуу аюулыг таних, аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг бууруулах, дотоод хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.4.5. нисэхийн аюулгүй байдлын өгөгдөлд дүн шинжилгээ хийж, үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэлийг баталгаажуулах;

3.4.6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөний дагуу иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх;

3.4.7. иргэний нисэхийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй аюулгүй байдлын асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

3.4.8. иргэний нисэхийн аюулгүй байдлыг сурталчлах сургалт, сурталчилгааны ажлыг дэмжих, идэвхтэй оролцох.

Дөрөв. Баримт бичгийн хяналт

4.1. Энэ журам, түүний нэмэлт өөрчлөлт, бүртгэл хөтлөлтийн хариуцагч нь Иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж байна.

4.2. Энэ журамд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа салбарын оролцогч талуудаас нээлттэй санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

4.3. Энэ журмын батлагдсан эх хувийг цахим хэлбэрээр www.mcaa.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулж түгээх ба албан ёсны англи хэл дээрх орчуулгыг ОУИНБ-д хүргүүлнэ.

Тав. Нисэхийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах

5.1. Иргэний нисэхийн ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.1.1. иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэл болон чиг хандлагыг тогтмол хянах;

5.1.2. аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр нөлөөг үнэлэх, дүн шинжилгээ хийх;

5.1.3. иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэлийг иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага болон холбогдох бусад оролцогч талуудад нээлттэй танилцуулах;

5.1.4. энэ журмаар тогтоосон иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны шаардлагын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, тасралтгүй сайжруулах;

5.1.5. иргэний нисэхийн аюулгүй байдалд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

5.1.6. олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх.

Зургаа.Монгол Улсын иргэний нисэхийн хууль
тогтоомж, эрх зүйн орчин

6.1.Монгол Улс ОУИНБ-ын стандарт, зөвлөмжид нийцсэн хууль тогтоомж, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

6.2.Нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хангуулах зорилгоор аливаа хүн, хуулийн этгээд нь Монгол Улсын хууль, иргэний нисэхийн дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

6.3.Монгол Улсын иргэний нисэхийн эрх зүйн орчин нь дараах 3 түвшинтэй байна:

6.3.1.иргэний нисэхийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх үндсэн хууль тогтоомж:

-Иргэний нисэхийн тухай хууль;

-Улсын нисэхийн тухай хууль;

-Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль.

6.3.2.Конвенц, түүний Хавсралтууд, ОУИНБ-ын стандарт, зөвлөмжийг үндэсний зохицуулалт болгон баталсан нисэхийн үйл ажиллагаанд заавал дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг:

-иргэний нисэхийн дүрэм;

-иргэний нисэхийн салбарын техникийн баримт бичиг;

-эрх бүхий байгууллагаас салбарын хэмжээнд заавал дагаж мөрдөхөөр гаргасан захиргааны хэм хэмжээний акт, захиргааны акт.

6.3.3.Иргэний нисэхийн ерөнхий газраас баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн зөвлөмжийн цуврал, маягт, журам, заавар, гарын авлага, зөвлөмжийн материал:

-зөвлөмжийн цуврал;

-журам, заавар;

-гарын авлага;

-шалгах хуудас;

-ажлын зааварчилгаа;

-Конвенцын Хавсралтад заасны дагуу иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаас хүлээн зөвшөөрсөн журам, заавар, гарын авлага;

-зөвлөмжийн материал.

6.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хууль тогтоомж болон ОУИНБ-ын стандарт, зөвлөмжийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн иргэний нисэхийн дүрэм, техникийн баримт бичиг, журам, заавар, зөвлөмжийн цувралыг тухай бүр шинэчилж, нийцлийг тогтмол хянана.

6.5.Иргэний нисэхийн ерөнхий газар нь энэ журмын 6.4-т заасан баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах үйл явцыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулна.

Долоо.Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх

7.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь салбарын хэмжээнд хууль, иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйд иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах замаар нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хангуулна.

7.2.Иргэний нисэхийн дүрмийг албадан хэрэгжүүлэх үйл ажиллагааг Конвенцын Хавсралт 19-д нийцсэн хууль, иргэний нисэхийн дүрэм, холбогдох журмаар зохицуулна.

7.3.Иргэний нисэхийн ерөнхий газар нь албадан хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэхдээ дараах зарчмыг баримтална:

7.3.1.хууль, дүрмийг сайн дурын үндсэн дээр байнга даган мөрддөг байх соёлыг дэмжих;

7.3.2.хууль, дүрмийн хэрэгжилтэд тавих хяналт шалгалтын үйл ажиллагааг ил тод, шударгаар хэрэгжүүлэх;

7.3.3.болзошгүй осол, зөрчлийг эрт илрүүлэх, давтан гарахаас урьдчилан сэргийлэх;

7.3.4.хяналт шалгалтын явцад гарсан үл нийцэл, дутагдал бүрд тохирсон албадан хэрэгжүүлэх арга хэмжээг авах;

7.3.5.тэнцвэртэй байх, ижил төстэй зөрчилд ижил төрлийн албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

7.3.6.хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

7.3.7.хувийн ашиг сонирхлоос ангид байж, гадны нөлөөнд үл автах;

7.3.8.хүйс, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоор ялгаварлахгүй байх.

7.4.Иргэний нисэхийн ерөнхий газрын эрх бүхий хяналтын байцаагч албадан хэрэгжүүлэх арга хэмжээг авахдаа зөвхөн тухайн нөхцөл байдалд үндэслэхгүйгээр илэрсэн үл нийцэл, дутагдал гарах болсон шалтгаан, нөхцөл болон үйлдэл, эс үйлдэхүй гаргасан этгээдийн зөрчлийн түүх зэргийг харгалзан үзнэ.

7.5.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Конвенцын Хавсралт 19 болон хууль, иргэний нисэхийн дүрэм, холбогдох журмын дагуу хүн, хуулийн этгээдэд албадан хэрэгжүүлэх арга хэмжээг дараах үндэслэлээр авна:

7.5.1.хууль болон дүрмийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй;

7.5.2.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

7.5.3.нисэхийн аюулгүй байдалд эрсдэл дагуулах нөхцөл байдал үүссэн;

7.5.4.гэрчилгээ эзэмшигч хүн, хуулийн этгээд нь нислэгийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг хангаж чадахгүй болсон, эсхүл болзошгүй гэж үзвэл;

7.5.5.хяналт шалгалтын дагуу албан журмаар өгсөн зөвлөмж, шаардлагыг биелүүлээгүй;

7.5.6.үнэмлэх, гэрчилгээгээр олгосон эрх, зөвшөөрлийн нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн;

7.5.7.дүрмээр шаардсан бүртгэлийг зохих ёсоор хөтлөөгүй;

7.5.8.эрх бүхий хяналтын байцаагчийг агаарын хөлөг, түүний эд анги, барилга байгууламж, талбай болон бүртгэлд үзлэг шалгалт хийх зорилгоор нэвтрэхэд саад болсон, эсхүл үндэслэлгүй шалтгаанаар татгалзсан;

7.5.9.үндсэн үйл ажиллагааны баримт бичиг, тайлан болон бүртгэлийг хуурамчаар үйлдсэн, эсхүл засварласан, нөхөн үйлдсэн;

7.5.10.албан үүрэг гүйцэтгэж байхдаа согтууруулах ундаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн.

7.6.Конвенцын Хавсралт 19-ийн дагуу хүн, хуулийн этгээд дараах үйлдлийг гаргасан тохиолдолд албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах нөхцөлд тооцох ба холбогдох хууль, иргэний нисэхийн дүрэм, журамд нийцүүлэн энэ журмын 7.5-д заасан үндэслэлээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэнэ:

7.6.1.илт хайхрамжгүй үйлдэл;

7.6.2.санаатай зөрчил, мэдээлэл нуух;

7.6.3.хууль, иргэний нисэхийн дүрэм санаатай зөрчих;

7.6.4.аюулд шууд хүргэх үйлдэл.

7.7.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Конвенцын Хавсралт 19-ийн дагуу иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь аливаа аюул, хүний хүчин зүйлийн алдаа, зөрчлийг хэрэгжүүлж байгаа аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хүрээнд илрүүлэх, залруулах боломжийг бүрдүүлнэ.

7.8.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Конвенцын Хавсралт 19-ийн дагуу аюулгүй байдлын өгөгдөл дамжуулах тогтолцооны хүрээнд нууцаар, эсхүл сайн

дураар дамжуулсан мэдээллийг албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах үндэслэл болгохгүй бөгөөд зөвхөн тухайн мэдээллийн дагуу хийгдсэн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтээр албадан хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэнэ.

Найм.Иргэний нисэхийн үйл ажиллагаа

8.1.Иргэний нисэхийн үйл ажиллагаа нь дараах байгууллагуудын хамтын үйл ажиллагаанаас бүрдэнэ:

-ОУИНБ;

-Олон улсын иргэний нисэхийн бусад байгууллага;

-Монгол Улсын Засгийн газар;

-Төрийн захиргааны төв байгууллагууд;

-Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба;

-Иргэний нисэхийн ерөнхий газар;

-Холбогдох бусад нисэхийн салбарын үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага;

-Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага;

“Иргэний нисэхийн дүрмээр үнэмлэх, зэрэглэл эзэмшигч мэргэжлийн ажилтнууд;

-Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогч бусад хуулийн этгээд.

8.2.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Иргэний нисэхийн ерөнхий газар нь энэ журмын 8.1-д заасан салбарын оролцогч талуудын идэвхтэй хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдааг хангуулж, иргэний нисэхийн аюулгүй байдлыг бататгана.

8.3.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор “Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл”-ийг байгуулна. Зөвлөлийн дарга нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

8.4.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

8.5.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь дараах байгууллагын удирдах албан тушаалтны төлөөллөөс бүрдэнэ:

8.5.1.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

8.5.2.Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

8.5.3.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

8.5.4.Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба;

8.5.5.Иргэний нисэхийн ерөнхий газар;

8.5.6.Онцгой байдлын ерөнхий газар;

8.5.7.Ус цаг уур, орчны шинжилгээний газар;

8.5.8.Зэвсэгт хүчний Жанжин штаб;

8.5.9.Агаарын цэргийн командлал;

8.5.10.иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага.

8.6.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөг батална.

8.7.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөг гурван жилээр төлөвлөн боловсруулна.

8.8.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөлтийг хэлэлцэж, хэрэгжилтийг хангана.

8.9.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь нисэхийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргана:

8.9.1.иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт;

8.9.2.Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөний хэрэгжилт;

8.9.3.салбарын хэмжээнд аюулгүй байдлыг хангуулахад шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадамж, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл болон бусад шаардлагатай нөөцийн бэлэн байдал;

8.9.4.аюулгүй байдлыг хангуулах зорилгоор иргэний нисэхийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал;

8.9.5.салбарын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан өөрчлөлт, шилжилтийн гүйцэтгэл;

8.9.6.иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэл;

8.9.7.аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийн дүн шинжилгээний тайлан;

8.9.8. нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт, хяналт шалгалтаар илэрсэн үл нийцэл, шаардлагын хэрэгжилт;

8.9.9. агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилт;

8.9.10. нисэхийн салбарт агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил, эсхүл онцгой байдал, хямралын нөхцөл үүссэн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөлт (Emergency Response Planning) болон хямралын удирдлагыг (Crisis Management) хэрэгжүүлэх арга хэмжээ.

8.10. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн хурлыг жилд нэг удаа, эсхүл шаардлагатай тохиолдолд шуурхай зарлан зохион байгуулна.

8.11. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл нь Ажлын албатай байх бөгөөд Ажлын албаны дарга нь Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

8.12. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба нь тус газрын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж болон бусад хяналт хариуцсан нэгжийн иргэний нисэхийн хяналтын ахлах байцаагч нараас бүрдэнэ.

8.13. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба дараах асуудлыг хэлэлцэнэ:

8.13.1. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал;

8.13.2. иргэний нисэхийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал;

8.13.3. иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх асуудал;

8.13.4. Иргэний нисэхийн тухай хууль, иргэний нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй, аюулгүй байдалтай холбоотой асуудал;

8.13.5. иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт, төлөвлөлттэй холбоотой асуудал;

8.13.6. хөндлөнгийн аудит, хяналт шалгалтын тайлан, тэдгээрийн хэрэгжилт, тулгамдсан асуудал;

8.13.7. агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвартай холбоотой болон бусад төрлийн аюулгүй байдлын мэдэгдэл гаргах асуудал;

8.13.8. иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээ;

8.13.9. иргэний нисэхийн үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэл;

8.13.10. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ, хэрэгжилт;

8.13.11.энэ журмыг Хавсралт 19-д нийцүүлэн хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө;

8.13.12.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт;

8.13.13.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэх асуудал;

8.13.14.энэ журамд нэмэлт, өөрчлөлт оруулах санал.

8.14.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба нь улирал тутам, эсхүл шаардлагатай тохиолдолд шуурхай зарлан хуралдаж, нисэхийн аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой улсын ерөнхий байцаагчийн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж ажиллана.

8.15.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөний хэрэгжилт, ОУИНБ-ын стандарт, зөвлөмж болон үндэсний баримт бичгийн нийцэл, хяналт зохицуулалтын үйл ажиллагаа, аюулгүй байдлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавих, дүн шинжилгээ хийх үүрэг бүхий Техникийн багтай байна.

8.16.Техникийн баг нь Иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж болон бусад хяналтын нэгжийн иргэний нисэхийн хяналтын байцаагч, шаардлагатай бусад мэргэшсэн ажилтнуудаас бүрдэнэ.

8.17.Техникийн баг нь улирал тутам хуралдаж, дүн шинжилгээний тайлан, шийдвэрлэх асуудлыг Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны хурлаар хэлэлцүүлнэ.

Ес.Иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага

9.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг аюулгүй байдлын дүн шинжилгээнд суурилсан үйл явцаар хэрэгжүүлнэ.

9.2.Иргэний нисэхийн ерөнхий газар нь дараах эх үүсвэрээс аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх замаар иргэний нисэхийн салбарын аюулыг таньж, илрүүлэх аргачлалыг бий болгож, хадгална. Үүнд:

9.2.1.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгасан тайлан, зөвлөмж;

9.2.2.хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;

9.2.3.иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн үр дүн;

9.2.4.заавал болон сайн дурын аюулгүй байдлын мэдээлэл;

9.2.5.үндэсний болон олон улсын бусад эх сурвалжаас ирсэн аюулгүй байдлын мэдээлэл.

9.3.Иргэний нисэхийн ерөнхий газар нь салбарын хэмжээнд аюулгүй байдлын заавал болон сайн дурын мэдээлэл дамжуулах тогтолцоог нэвтрүүлнэ. Мэдээлэл дамжуулах тогтолцооны дагуу хүний хүчин зүйл болон бусад нөхцөлөөс шалтгаалсан агаарын хөлгийн осол, үйл ажиллагааны зөрчил, алдаа, үл нийцлийн тохиолдол гарахаас урьдчилан сэргийлнэ.

9.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын дотоод мэдээлэл дамжуулах тогтолцоо нь холбогдох дүрэм, журмын шаардлагад нийцэж буй эсэхэд хяналт тавина.

9.5.Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлэх Техникийн баг нь салбарын хэмжээний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд улирал тутам танилцуулна.

9.6.Иргэний нисэхийн ерөнхий газар нь салбарын аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг ОУИНБ-ын стандарт, шаардлагад нийцсэн бүтэц бүхий, баримтажсан, давтагдах боломжтой аргачлалаар явуулж, эрсдэлийн давтамж, ноцтой байдлыг тодорхойлон, эрсдэлийн түвшнийг ангилж, эрсдэлийн сангийн бүртгэлд баримтжуулсан байна. Бүртгэлд эрсдэлийн үнэлгээ, хариуцсан байгууллага, тохиролцсон эрсдэлийн хяналт болон эрсдэлийг бууруулах арга хэмжээг багтаасан байна.

9.7.Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг хэрэгжүүлэх Техникийн баг нь иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын эрсдэлийг тохиромжтой хугацаанд давтан үнэлж, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавина.

9.8.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын эрсдэлийг удирдах дараах арга хэмжээг хэрэгжүүлэх ба энэхүү үйл явц нь илэрсэн эрсдэлийг бууруулах, уг арга хэмжээг шинэчлэн иргэний нисэхийн аюулгүй байдлыг тогтмол хангуулах үндсэн аргачлал болно. Үүнд:

9.8.1.эрсдэлийг бууруулах, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтоож, хэрэгжүүлэх;

9.8.2.эрсдэлийг бууруулах арга хэмжээний хяналт, хариуцлагыг тодорхойлох;

9.8.3.тухайн эрсдэлийг бууруулахтай холбоотой үйл ажиллагааг баримтжуулж, дагаж мөрдөх;

9.8.4.аюулгүй байдлын заавар, мэдэгдэл, зааварчилгааны материал гаргах;

9.8.5.аюулгүй байдлын сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах;

9.8.6.Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөнд тусгагдсан аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээтэй уялдуулах.

9.9.Иргэний нисэхийн ерөнхий газар нь салбарын аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр нөлөөг үнэлэхдээ үйл ажиллагааны аюулгүй байдлын

гүйцэтгэл, салбарын чиг хандлагын тандалт, иргэний нисэхийн хяналт шалгалтын үр дүн болон бүртгэгдсэн аюулгүй байдлын мэдээллийг ашиглана.

9.10. Аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр нөлөө хангалтгүй гэж үнэлсэн тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газраас эрсдэлийг бууруулах арга хэмжээг шинэчлэх, Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөг шинэчлэх зэрэг арга хэмжээг авна.

Арав. Иргэний нисэхийн аюулгүй байдлын баталгаажуулалт

10.1. Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцэх, бодитой хэрэгжих боломжтой аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшин, анхааруулах түвшнийг ОУИНБ-ын стандарт, зөвлөмж, Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөнд тус тус нийцүүлэн тогтооно.

10.2. Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшин, анхааруулах түвшин нь дараах шаардлагыг хангасан байна:

10.2.1. үр дагавар өндөр болон бага түвшний эрсдэлтэй аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг хослуулсан байх;

10.2.2. тухайн байгууллагын үйл ажиллагаатай шууд холбоотой байх;

10.2.3. ижил салбар, ангилалд хамаарах бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үзүүлэлтүүдтэй нийцсэн байх;

10.2.4. энэ журам болон Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөөнд нийцсэн байх.

10.3. Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, аюулгүй байдлын гүйцэтгэл анхааруулах түвшинд хүрсэн тохиолдолд авч хэрэгжүүлэх залруулах арга хэмжээний төлөвлөгөөг баримтжуулсан байна.

10.4. Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгийг анхан шатанд хянах, хүлээн зөвшөөрөх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

10.5. Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшин, анхааруулах түвшнийг хүлээн зөвшөөрч, тогтмол хянана. Тус газрын аюулгүй байдлын гүйцэтгэлд тавих хяналт, үнэлэх үйл явц нь хяналтад хамрагдаж байгаа байгууллагад ил тод, ойлгомжтой байна.

10.6. Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлын баталгаажуулалтыг аудит эсхүл хяналт шалгалт болон бүртгэгдсэн аюулгүй байдлын

мэдээллийн дагуу Хавсралт 19-ийн хүрээнд хийх шинжлэн шалгах ажиллагаанд үндэслэн дараах аргачлалаар гүйцэтгэнэ:

10.6.1.салбарын хэмжээнд аюулгүй байдлын эрсдэлийн хяналтын арга хэмжээний үр нөлөөг баталгаажуулах;

10.6.2.иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны үр нөлөөг үнэлэх;

10.6.3.салбарын үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэлийг хянах тасралтгүй сайжруулах.

10.7.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нэмэлт зааварчилгааны материалыг боловсруулж, нийтэлнэ.

10.8.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд болон мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл эзэмшигч ажилтнуудын үйл ажиллагаа иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах аргачлалыг тогтоосон хяналт шалгалтын заавар болон түүнийг дагалдан гарах бусад баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

10.9.Иргэний нисэхийн ерөнхий газар нь эрсдэлд суурилсан хяналт шалгалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хэрэгжүүлнэ.

10.10.Иргэний нисэхийн хяналт шалгалтын төлөвлөгөө нь аюулгүй байдлын гүйцэтгэл, эрсдэлийн удирдлага болон аюулгүй байдлын мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн тогтоосон хамгийн өндөр эрсдэлийг бууруулахад чиглэх бөгөөд хяналтын цар хүрээ, давтамжийг тохируулах аргачлалд тулгуурлан боловсруулна.

10.11.Иргэний нисэхийн ерөнхий газар нь хяналт шалгалтын хөтөлбөрт иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоонд хийх хяналтыг багтаасан байна. Тус хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

10.11.1.тухайн байгууллагын аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны баримт бичгийг жил бүр, эсхүл хоёр жил тутам хянаж, тогтоосон зохицуулалт нь байгууллагын хэрэгцээнд нийцсэн хэвээр байгаа эсэхийг баталгаажуулах;

10.11.2.аюулгүй байдлын гүйцэтгэлийг урьдчилан тохиролцсон гүйцэтгэлийн үзүүлэлт, зорилтот түвшин, анхааруулах түвшнийг ашиглан үе шаттайгаар үнэлж, тухайн байгууллагад тохирсон хэвээр байгаа эсэхийг баталгаажуулах;

10.11.3.аюул илрүүлэх, аюулгүй байдлын эрсдэлийг удирдах үйл явц нь ОУИНБ-ын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах.

10.12.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналтыг хийх аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжтэй байна.

10.13.Иргэний нисэхийн ерөнхий газар нь дотоод хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

10.13.1.иргэний нисэхийн хяналт, зохицуулалт Конвенцын шаардлагад нийцэж байгаа эсэх;

10.13.2.иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын хэрэгжилт хангагдсан эсэх;

10.13.3.аюулгүй байдлын хяналт, зохицуулалтад шаардлагатай хангалттай мэргэшсэн хүний нөөц, тоног төхөөрөмж, багаж, тээврийн хэрэгсэл, ажлын байр болон холбогдох санхүүжилтийг бий болгосон эсэх.

10.14.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын чадамжийг ОУИНБ-ын стандарт, зөвлөмжийн дагуу үнэлнэ.

10.15.Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудит, хяналтын үйл ажиллагаа нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, олон улсын стандарт, шаардлага, шилдэг туршлагад нийцүүлэхэд чиглэсэн байна.

10.16.Иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж нь энэ журмын 3.1.23-т заасан холбогдох бүртгэл, мэдээллийн санг үүсгэж, дүн шинжилгээ хийн, тогтмол хянана.

10.17.Аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийн чанарыг дараах шалгуураар үнэлнэ:

10.17.1.баталгаажилт: цуглуулсан өгөгдөл нь тодорхой зорилгоор ашиглахад тохиромжтой, тогтоосон шалгуурт нийцсэн байх;

10.17.2.бүрэн бүтэн байдал: мэдээллийн холбогдох бүх өгөгдөл бүрэн байх;

10.17.3.нийцтэй байдал: үзүүлэлтийг хэмжихэд үр дүн нь давтагдах чадвартай, алдаагүй байх;

10.17.4.хүртээмж: мэдээлэлд анализ хийхэд бэлэн, авч ашиглах боломжтой байх;

10.17.5.цаг хугацааны нийцэмж: мэдээлэл нь хэрэгжүүлэх цаг үе, нөхцөлд тохирсон бөгөөд шуурхай олж авах боломжтой байх;

10.17.6.мэдээллийн хамгаалалт: мэдээллийг санамсаргүй, эсхүл санаатайгаар өөрчлөгдөхөөс хамгаалсан байх;

10.17.7.үнэн зөв байдал: мэдээлэл нь алдаагүй, үнэн зөв байх.

10.18.Иргэний нисэхийн ерөнхий газар нь салбарын аюул, эрсдэлийн мэдээллийг цуглуулах, хадгалах аргачлалыг Конвенцын Хавсралт 19-д нийцүүлэн хэрэгжүүлнэ.

10.19.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын өгөгдөл, мэдээллийг дараах эх үүсвэрээс цуглуулж, дүн шинжилгээ хийн, хадгалж, хамгаална:

10.19.1.агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгасан тайлан;

10.19.2.сайн дурын осол, зөрчлийн мэдээллийн систем;

10.19.3.заавал дамжуулдаг осол, зөрчлийн мэдээллийн систем;

10.19.4.үйлчилгээ үзүүлэгчдээс шууд авсан үйл ажиллагааны өгөгдөл;

10.19.5.аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны өгөгдөл, мэдээлэл.

10.20.Иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүй байдлын мэдээллийн сан дараах мэдээллийг агуулна:

10.20.1.агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгасан мэдээлэл-ослын шалтгаан, нөхцөл байдлын мэдээлэл;

10.20.2.заавал дамжуулах осол, зөрчлийн мэдээлэл-тайлан, дүн шинжилгээ;

10.20.3.сайн дурын мэдээлэл-хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн сайн дурын мэдээлэл;

10.20.4.агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтын мэдээллийн өгөгдөл;

10.20.5.үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналтын өгөгдөл-агаарын хөлгийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд;

10.20.6.аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ-эрсдэлийн дүн шинжилгээ, үнэлгээний мэдээлэл;

10.20.7.аудитын тайлан, үл нийцэл-дотоод болон гадаад аудитын үр дүн;

10.20.8.аюулгүй байдлын судалгаа, тойм-судалгааны дүн, аюулгүй байдлын дүгнэлт;

10.20.9.гадаад улс орон болон бүс нутгийн байгууллагын аюулгүй байдлын мэдээлэл.

10.21.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын мэдээллийн санд хадгалагдсан өгөгдлөөс мэдээлэл боловсруулах, боловсруулсан мэдээллээ салбарын байгууллагууд болон бусад улстай солилцох, хэрэглэх боломжоор хангасан байна.

10.22.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтыг хариуцах бөгөөд үндэсний болон ОУИНБ-ын стандарт, зөвлөмжид нийцүүлэн мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэгжүүлнэ.

10.23.Иргэний нисэхийн ерөнхий газар нь өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлж, салбарт гарч буй өөрчлөлтийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тодорхойлох, төлөвлөх болон санал болгож буй өөрчлөлтийг шилжилтийн бүтэцтэй, зохион байгуулалттай байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

10.24.Өөрчлөлтийн удирдлагын үйл явц нь дараах өөрчлөлтөөс үүсэх эрсдэлийг хамарч болно. Үүнд:

10.24.1.Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт;

10.24.2.энэ журмын үйл явцын өөрчлөлт болон эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үйл ажиллагаа, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага болон аюулгүй байдлын баталгаажуулалтын үйл явцад хийх өөрчлөлт;

10.24.3.хууль тогтоомж, эрх зүйн орчны өөрчлөлт;

10.24.4.иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилтод хийх өөрчлөлт;

10.24.5.салбарт шинээр технологи, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон үйлчилгээг нэвтрүүлэх өөрчлөлт;

10.24.6.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны аюулгүй байдлын гүйцэтгэлийг хянах чадамжид салбарын хурдацтай өсөлтийн үзүүлэх үр нөлөө.

Арван нэг.Иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалт, сурталчилгаа

11.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын эерэг, шударга соёлыг хөгжүүлэх, энэ журмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аюулгүй байдлын сургалт, мэдлэгийг түгээх, хоёр талт харилцааг бий болгоно. Үүнд:

11.1.1.салбарын нийт ажилтанд нисэхийн аюулгүй байдлын мэдээлэл, мэдлэг, зөвлөгөө өгөх;

11.1.2.хяналт, зохицуулалтын үүрэг хүлээсэн ажилтнуудад дэмжлэг үзүүлэх, сургалт явуулах;

11.1.3.салбарын хэмжээнд аюулгүй байдлын болон бусад шаардлагатай мэргэшүүлэх чиглэлийн анхан шатны болон давтан сургалт, семинар, зөвлөгөөнийг жил бүр төлөвлөн, зохион байгуулах.

11.2.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагааг ашиг сонирхлоос ангид, хууль, дүрмийн дагуу гүйцэтгэх шаардлагыг сурталчлан таниулж, ажилтнууд хооронд өмнөх туршлага, шаардлагатай мэдээллийг нээлттэй солилцдог, багаар хэлэлцэж хамтын зөв шийдвэр гаргадаг үйл явцыг бүрдүүлнэ.

11.3.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг олон нийтэд www.mcaa.gov.mn цахим хуудсаар хүргэнэ.

11.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь мэдээлэл солилцох, түгээх дараах сувгийг бий болгоно. Эдгээр суваг нь аюулгүй байдлын мэдээллийг цаг тухайд нь, үр дүнтэй түгээх, аюулгүй байдлын соёлыг төлөвшүүлэхэд чиглэнэ:

11.4.1.нэн чухал, нууцлалтай аюулгүй байдлын мэдээллийг дараах сувгаар түгээнэ:

-Нууц захидал (Confidential Letters);

-Албан бичиг;

-Цахим шуудан.

11.4.2.нэн чухал бус нийтэд хүргэх аюулгүй байдлын мэдээллийг дараах сувгаар нээлттэй байршуулна:

-Иргэний нисэхийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас www.mcaa.gov.mn;

-Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод сүлжээ;

-Аюулгүй байдлын мэдээллийн самбар;

-Аюулгүй байдлын анхааруулга мэдээлэл;

-Аюулгүй байдлын мэдээллийн танилцуулга зурагт хуудас, материал (улирал тутам);

-Медиа контент;

-Аюулгүй байдлын сэтгүүл (жилд нэг удаа).

11.5.Иргэний нисэхийн ерөнхий газар нь нуугдсан аюул, зөрчлийг сайн дураар мэдээлж, тухайн мэдээлэл нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулсан, агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлсэн болох нь баталгаажсан тохиолдолд мэдээлэгч аливаа этгээдийг урамшуулж болно.

11.6.Иргэний нисэхийн ерөнхий газар нь энэ журмын 11.5-д дурдсан урамшуулахтай холбоотой зардлыг жил бүрийн төсөвт тусгасан байх бөгөөд аюулгүй байдлын мэдээлэгчийн хувийн мэдээллийн нууцлалыг хамгаална.

11.7.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Конвенцын Хавсралт 19-ийн дагуу аюулгүй байдлын мэдээллийг хуваалцах, солилцох харилцаа холбоог бий болгох замаар иргэний нисэхийн аюулгүй байдлыг сайжруулж, аюулгүй байдлын эерэг соёлыг төлөвшүүлнэ.

11.8.Аюулгүй байдлын харилцаа холбоо нь дараах зорилгод чиглэнэ:

11.8.1.бүх ажилтанд энэ журам болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны уялдаа холбоог танилцуулах;

11.8.2.аюулгүй байдлын хувьд нэн чухал мэдээллийг холбогдох төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдэд дамжуулах;

11.8.3.тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх болсон үндэслэл, шалтгааныг тайлбарлах;

11.8.4.энэ журмын ач холбогдол, нэмэлт өөрчлөлтийг танилцуулах;

11.8.5.салбарын хэмжээнд “Мэдвэл зохистой” мэдээллийг түгээх.

11.9.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад дараах дэмжлэгийг үзүүлнэ:

11.9.1.аюулгүй байдлын эрсдэлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх;

11.9.2.аюулгүй байдлын мэдээллийн хоёр талт харилцааг дэмжих;

11.9.3.аюулгүй байдлын эерэг, шударга соёлыг төлөвшүүлэх сургалт, мэдээллийг олгох.

11.10.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг дэмжих сургалт, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулж, аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах болон аюулгүй байдлын соёлыг төлөвшүүлэхийг зорино.

11.11.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд болон салбарын оролцогч талуудтай тогтмол уулзалт зохион байгуулж, шинээр гарах дүрэм журам, хяналт, зохицуулалтын өөрчлөлтийн талаар мэдээлнэ.

11.12.Иргэний нисэхийн ерөнхий газар нь гадаад, дотоодын салбарын оролцогч талуудтай нээлттэй харилцана.

11.13.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсыг олон улсад төлөөлж, иргэний нисэхийн аюулгүй байдлын хурал, уулзалт, арга хэмжээнд оролцож, Ази, Номхон далайн бүс нутгийн Аюулгүй байдлын багт байнгын гишүүнээр элсэнэ.

11.14.Иргэний нисэхийн ерөнхий газар нь хоёр жил тутам иргэний нисэхийн аюулгүй байдлын “Safety Road” зөвлөгөөнийг зохион байгуулна.

11.15.Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдлын дотоод сургалтын бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

11.16.Сургалтын хөтөлбөр дараах ангилалтай байна:

11.16.1.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга бөгөөд ерөнхий байцаагч болон нисэхийн салбарын бусад удирдлага (төрийн байгууллага, салбарын байгууллагууд)-д зориулсан Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө, иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт болон аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийн талаарх танилцуулах сургалт;

11.16.2.иргэний нисэхийн хяналтын байцаагчдад зориулсан Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны мэргэшүүлэх сургалт;

11.16.3.Иргэний нисэхийн ерөнхий газрын нийт ажилтанд зориулсан аюулгүй байдалтай холбоотой үүрэг, хариуцлагын талаарх ойлголт, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой сургалт.

11.17.Сургалтын хөтөлбөр нь зөвхөн Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнаар хязгаарлагдахгүй бөгөөд салбарын байгууллагууд хүсэлт тавьж, шаардлагатай сургалтыг гэрээлэн авах боломжтой.

11.18.Сургалтын хөтөлбөрийн агуулгад дараах шаардлага тавигдана. Үүнд:

11.18.1.танилцуулах/анхан шатны аюулгүй байдлын сургалт:

Зорилго: Суралцагчдад Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын бодлого, зорилт, Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны үндсэн ойлголтыг танилцуулах, аюулгүй байдлын үүрэг, хариуцлага, аюул, зөрчлийг мэдээлэх тогтолцооны талаар ерөнхий ойлголт өгөх.

Агуулга:

-Аюул, үр дагавар болон эрсдэл;

-Аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын үйл явц, оролцогч талуудын үүрэг, хариуцлага;

-Аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоо;

-Үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын аюулгүй байдлын мэдээлэл дамжуулах тогтолцоо.

11.18.2.ажлын байран дээрх аюулгүй байдлын сургалт (OJT):

Зорилго:Суралцагчдад ажлын чиг үүрэг, албан тушаалын хариуцлагад хамаарах аюулгүй байдлын ойлголт, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын үйл явцтай танилцуулах.

Агуулга:

-Аюул тодорхойлох болон эрсдэлийн удирдлагын үйл явц;

-Аюулгүй байдлын өгөгдөл цуглуулах болон шинжилгээ хийх;

-Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалт.

11.18.3.аюулгүй байдлын давтан сургалт:

Зорилго:Суралцагчдыг аюулгүй байдлын үүрэг, хариуцлагатай илүү гүнзгий танилцуулах. Үүнд үндэсний болон байгууллагын аюулгүй байдлын шаардлагыг мөрдөх, нөөцийн зохистой хуваарилалт, хэлтэс хоорондын үр дүнтэй харилцаа холбоог бий болгох, энэ журмын хэрэгжилтийг дэмжих, сурталчлах агуулга багтана.

Агуулга:

-Аюулгүй байдлын үүрэг, хариуцлага;

-Аюулгүй байдлын баталгаажуулалт болон аюулгүй байдлын сурталчилгаа;

-Аюулгүй байдлын хүлээн зөвшөөрөгдөх түвшинг тогтоох болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны аюулгүй байдлын гүйцэтгэл.

11.18.4.удирдах түвшний ажилтанд зориулсан сургалт:

Зорилго:Удирдах түвшний ажилтанд иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын бүрэлдэхүүн хэсэг, элементийн талаар тусгайлсан ойлголт өгөхөд чиглэнэ.

Агуулга:

-Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын зохион байгуулалт;

-Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын хүрээнд хүлээх үүрэг, аюулгүй байдлын хариуцлага;

-Аюулгүй байдлын бодлого болон зорилтууд;

-Аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага;

-Аюулгүй байдлын баталгаажуулалт;

-Аюулгүй байдлын сурталчилгаа;

-Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний төлөвлөгөө.

11.19.Иргэний нисэхийн ерөнхий газрын сургалтын үйл ажиллагааг аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж баримтжуулна.

11.20.Иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээнд нийцүүлэн боловсруулна.

Арван хоёр.Санхүүжилт

12.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь энэ журмыг хэрэгжүүлэхэд зардлыг жил бүр төсөвлөн батлуулна.

12.2.Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг жил бүр төсөвтөө тусган баталсан байна.

Арван гурав.Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын хэрэгжилтийг хянах, үнэлэх

13.1.Иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан нэгж нь энэ журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлнэ.

13.2.Иргэний нисэхийн ерөнхий газар нь энэ журмын хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээг жил бүр Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

13.3.Энэ журмын хэрэгжилтийг ОУИНБ-аас тогтоосон аюулгүй байдлын журмын хэрэгжилтийг үнэлэх аргачлалыг баримтлан аюулгүй ажиллагаа, сургалт, стандартын хэрэгжилтийн цахим систем (Operational Learning Framework)-ээр дамжуулан үнэлж, хяналт тавина.

Арван дөрөв.Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын
журмын шалгуур үзүүлэлт

14.1.Энэ журмыг хэрэгжүүлснээр иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын үйл ажиллагааны шаардлагыг баталгаажуулж, аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлт, анхааруулах түвшин, зорилтот түвшин зэрэг үзүүлэлтийг хэмжиж, тасралтгүй сайжруулах боломжийг бүрдүүлнэ.

14.2.Энэ журмын үндсэн шалгуур нь ОУИНБ-ын “Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон улсын аудит хөтөлбөр-Байнгын хяналтын аргачлал (USOAP-CMA)” аудитын “Хамрах хүрээ 9. Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-ын протокол асуулт болон Конвенцын Хавсралт 19-ийн нийцлийн шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлсон тоон утгаар илэрхийлэгдэнэ.